



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ  
УЛААН ТУГИЙН ОДОНТ  
**АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2022 оны 04 сарын 25 өдөр

Дугаар A/23

Улаанбаатар хот

Г Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд  
резидент эмчийн бие даан үзүүлэх  
өвчиний жагсаалт батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 22.1.7, 22.1.8, 22.2.2 зүйл заалт, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 04 сарын 09-ний өдрийн A/226 тоот тушаалыг үндэслэн Тушаах нь:


1. Эмнэлгийн тусlamж, үйлчилгээнд Резидент эмчийн бие даан үзүүлэх өвчиний олон улсын 10-р ангиллын код бүхий өвчнүүдийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.
2. Тус төвийн арьс судлалын эмнэлзүйн үйл ажиллагаанд бие даан эмнэлгийн тусlamж үйлчилгээ үзүүлэхдээ хавсралтаар баталсан өвчиний жагсаалтын дагуу үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх, уг ажлыг гүйцэтгэхдээ мэргэшсэн эмчээс арга зүйн туслалцаа авах, ажлыг гүйцэтгэх явцад аливаа хүндрэл гарсан тохиолдолд мэргэшсэн эмчид цаг алдалгүй мэдэгдэх үүргийг резидент эмч нар хэрэгжүүлсүгэй.
3. Резидент эмчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, өөрийнх нь шууд хяналт, удирдлагад ажиллах резидент эмчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, оношлох, эмчлэх зорилгоор үйлчлүүлэгчид үзлэг, шинжилгээ, оношилгоо хийх ажлыг резидент эмчээр гүйцэтгүүлж болох бөгөөд энэ тохиолдолд резидент эмчид зөвшөөрөл олгосон шийдвэрийг бичгээр үйлдэж, удирдах албан тушаалтанд мэдэгдэх эрх үүргийн хүрээнд хэрэгжүүлэхийг мэргэшсэн эмч нарт үүрэг болгосугай.
4. Эрүүл мэндийн тусlamж үйлчилгээний чанар аюулгүй байдалд анхаарч ажиллахыг ЭМТҮЧАБ-ын албаны дарга /Б.Баярмаа/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ЭЗЭД захирал /Б.Батцэцэг/ нарт даалгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Ц.УРАНЧИМЭГ



АӨСҮТ-ийн Гүйцэтгэх захирлын  
2022 оны 04 дүгээр сарын 28-ний  
өдрийн 113 тоот тушаалын хавсралт



Резидент эмчийн бие даан үзүүлэх өвчний олон улсын  
10-р ангиллын код бүхий өвчнүүдийн жагсаалт

1. Түүхий L01
2. Хатги L02.2-L02.8
3. Атопийн дерматит, хөнгөн хэлбэр, БГТ 20 хүртэл хувь L20
4. Живхний дерматит L22
5. Хавьтал харшлын дерматит шалтгаан тодорхой L23-L23.8
6. Хайрст үлд L40.0, L40.4
7. Чонон хөрвөс хүндрэлгүй хэлбэр L50
8. Батга L70.0-L70.1
9. Арьсны үлд B35-B35.8
10. Бүслүүр үлд B02
11. Херпес вируст халдварт (herpes simplex) B00.
12. Халдварт моллюск B08.1
13. Хамуу B86
14. Вируст γγ B07.